

байгуулагдсан билээ. Энэхүү түүхэн үйл явцыг зохиогч “Монгол улс дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй хүчирхэг хэт их гүрэн АНУ-ын хооронд Дипломат харилцаа байгуулагдсан явдал манай улсын бүрэн эрхт байдал, олон улсын дундах байр суурийг үлэмжхэн бэхжүүлж, түүний улс төр техник эдийн засаг шинжлэх ухаан соёлын цаашдын хөгжил, нийгмийн амьдралд ихээхэн тус нэмэр болох түүхэн чухал ач холбогдолтой /60 дахь тал/ гэж зөв зүйтэй дүгнэсэн байна.

Монголын нэрт эрдэмтэн, академич Н.Ишжамц агсны туурвисан энэхүү бүтээл нь Монгол улсын улс төрийн гадаад харилцааны ажилтан, судлаачид, их дээд сургуулийн багш, оюутнуудын гарын авлага болохуйц чамбай бүтээл болсныг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

МОНГОЛ-ХЯТАДЫН ЭРДЭМТДИЙН ХАМТЫН БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

Монгол-Хятадын харилцаа өнгөрсөн зууны 90-ээд оноос улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан зэрэг нийгмийн амьдралын бүх салбарыг хамран эрчимтэй өргөн хөгжиж байна. Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын харилцаа ч урьд өмнө байгаагүйгээр өрнөн хөгжиж байна. Урьд өмнө хоёр орны эрдэмтэд хамтран эрдмийн бүтээл туурвих асуудал төдий л түгээмэл байсангүй. Сүүлийн хэдэн жилд шинжлэх ухааны бараг бүх салбарт хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж, эрдэмтэд харилцан солилцох, туршлага судлах, олон улсын хурал хамтран зохион байгуулах, сорилт туршилт хийх, хамтын бүтээл туурвих зэргээр үр бүтээлтэй, өгөөжтэй ажиллаж байна. Үүний нэг тодорхой жишээ нь: **“Монгол-Хятадын харилцаа: Нийгэм-эдийн засгийн зарим асуудал (XX зууны 90-ээд он)”** УБ.2001 он /хамтын бүтээл юм. Доктор Ph.Л.Бэгэжавын орчуулж, эмхэтгэсэн энэхүү хамтын бүтээл нь хоёр улсын эрдэмтдийн олон жилийн нягт хамтын ажиллагааны үр дүнд бий болсон гэж үзэх үндэстэй.

1998 онд манай хүрээлэн Зүүн хойт Азийн асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан билээ. Энэ хуралд ӨМӨЗО-ы Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн эрдэмтэд оролцож сонирхолтой хэд хэдэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм. Энэхүү номын үндсэн хэсэг нь дээрх илтгэлүүдээс сонгон авч оруулснаас гадна БНХАУ-ын Зилинь мужийн Зүүн Хойт Ази судлалын төвийн эрдэмтэд, монгол улсын эрдэмтдээс ЗХА, Монгол-Хятадын харилцаа, ӨМӨЗО-ы нийгэм-эдийн засгийн өргөн хүрээтэй асуудлаар бичсэн судалгааны өгүүлүүдээс бүрдэл болно.

Хамтын бүтээлд Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор Хайсандай өмнөтгөл бичиж энэ бүтээл нь хоёр орны эрдэмтэд ЗХА-ийн чиглэлд нягт хамтран ажиллаж байгаагийн нэг бодит илрэл гэж үнэлсэн байна.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн эмхтгэлд орсон материалыг өнгөц харахад монголын эрдэмтэд гол төлөв монгол хятадын эдийн засгийн хамтын ажиллагааг голлосон бол хятадын эрдэмтэд Монголын эдийн засаг нийгмийн амьдралын олон талт асуудлыг хөндөж бичсэн өгүүллүүд зонхилох байрыг эзлэж байна. Түүнчлэн Монгол Хятад хоёр улс хамтран Зүүн хойт Азийн эдийн засгийн интеграцид хэрхэн оролцох асуудлыг хөндсөн анхаарал сонирхол татахуйц судалгааны өгүүллүүд ч цөөнгүй харагдана.

Монголын нэрт эрдэмтэн академич Ч.Далай “Монголд улс төрийн шинэ тогтолцоо бүрэлдэж буй онцлог” гэсэн судалгааны даацтай өгүүлэлдээ Монголд улс төрийн шинэ тогтолцоо бүрэлдэн бий болж өсөн өндийж төлөвшиж эхлээд буйг ч тодорхой өгүүлээд одоогийн улс төрийн тогтолцооны эерэг сөрөг талыг нэлээд нухацтай авч үзжээ. Академич Ч.Далай өгүүлэлдээ Үндсэн хуульд зохих өөрчлөлт оруулах асуудлыг хөндсөн байна.

Монголын эрдэмтэн доктор Д.Ганзориг Монгол улсаас ОХУ-д төлөх зээлийн их өрийг зохицуулах асуудлаар судалгааны сонирхолтой өгүүлэл нийтлүүлсэн байна. Доктор Д.Ганзориг өгүүлэлдээ ЗХУ-аас Монгол улсад үзүүлсэн тусламж дэмжлэг нь зөвхөн эдийн засгийн хүрээгээр хязгаарлагдахгүй, цэрэг, улс төр, үзэл суртлын хүрээг хамаарсан тухайн үеийн тогтолцооны хувь заяатай холбоотой гарцаагүй шаардлагатай бодлого байсан гэдгийг жишээ баримтад тулгуурлан тодорхой харуулжээ. Түүгээр ч зогсохгүй зохиогч өөрийн судалгаандаа үндэслэн өр төлбөрийг зохицуулах хувилбаруудыг санал болгон дэвшүүлсэн нь энэ чиглэлийн бодлого боловсруулагчид зүй ёсоор анхаарч үзэхэд илүүдэхгүй бизээ.

Монголын эрдэмтэдээс бичсэн даацтай судалгааны өгүүллийн нэг нь манай зэгсэн хятад судлаач эрдэмтэн Л.Бэгэжавын бичсэн “Монгол-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны зарим асуудал (1990-1999) бүтээл юм. Зохиогч хоёр орны эдийн засгийн олон талт хамтын ажиллагааны сүүлийн 10 орчим жилийн үйл явцад судалгаа хийж үнэлэлт, дүгнэлт өгч, түүний эерэг сөрөг тал, эдийн засгийн үр ашиг хийгээд энэ нь Монголын эдийн засгийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх асуудлыг хөндсөн байна. Түүнчлэн хоёр орны эдийн засгийн олон талт хамтын ажиллагааны цаашдын төлөвийг ч тодорхой харуулснаараа чухал ач холбогдолтой юм.

Хятадын эрдэмтдээс Цао Лижигийн бичсэн “Монголын эдийн засгийн шинэчлэлийн үйл явцыг эрэгцүүлэх нь”, Цао Жункайн

“Монгол улсын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх нөөц боломжийн тухайд”, Нарангийн “Хоёр улсын эдийн засаг худалдааны харилцаа”, Баатарын “Монгол-Хятадын хамтын ажиллагааны урьд, одоо, ирээдүй”, Насангийн “Зүүн хойт Азийн бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол улсын эзлэх байр суурь, үзүүлэх нөлөө” зэрэг сонирхолтой өгүүллүүд оржээ. Хятадын эрдэмтэн судлаачдын өгүүллүүд нь гаднын хүний нүдээр бидний байгаа байдал, нөөц боломжийг харуулсан нь сонирхууштай, санаа авууштай зүйлс олонтаа харагдана. Энэ өчүүхэн танилцуулгад тэр бүрийг нэг нэгэнгүй харуулах боломжгүй тул уншигчдад шинэ номын мэдээлэл хүргэх үүднээс уг хамтын бүтээлд орсон өгүүллүүдээс түүвэрлэн цөөн хэдийг л дурьдсан болохыг болгооно бизээ.

Эцэст тэмдэглээд энэхүү хамтын бүтээл хоёр орны харилцааны асуудлыг сонирхон судалдаг, сэхээтэн мэрэгжилтэн, бодлого боловсруулагчид, гадаад харилцааны чиглэлийн багш, оюутнуудын сонирхон уншихуйц бүтээл болжээ.

М.ХУРМЕТХАН

**“МОНГОЛ УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН
ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА” (1945-1991)**

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн хувьд өнгөрсөн зууны сүүлчийн он эрдмийн бүтээлийн ургац арвинтай жил боллоо. Тус хүрээлэнгийн эрдэмтэдээс олон улсын болон монголын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, орон судлалын чиглэлээр хэд хэдэн бүтээл хэвлүүлэв. Түүний нэг нь Төв, Дундад Ази, ялангуяа Афган, Казакын судлалаар мэрэгшсэн эрдэмтэн Мухамед Хурметханы “ХХ зууны сэргэн мандлын гадаад харилцаа” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн “Монгол улс, Америкийн Нэгдсэн улсын харилцаа, хамтын ажиллагаа” (1945-1999) хэмээх бүтээл юм. Академич Н.Ишжамц агсан 1999 онд туурвиж хэвлүүлсэн “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа (1900-1987) номын шууд үргэлжлэл болох энэхүү ном оршил, 3 бүлэг, дүгнэлтийн хэсгээс бүрдэл болно. Зохиогчийн “Монгол улс, АНУ-ын харилцааны түүхээс XIX зууны эцсээс 1921 он хүртэл”, “БНМАУ, АНУ-ын харилцааны байдал” хэмээх эхний хоёр бүлэг нь зарим талаар академич Н.Ишжамц агсаны бүтээлтэй утга агуулга, ашигласан материалын хувьд давхцаж байгаа ч гэсэн зарим онцлог нэмэлт материал ашиглаж утга санааг баяжуулан тодруулснаараа зохих ач холбогдолтой, үнэ цэнэтэй болсон гэх үндэстэй байна. Энэ дашрамд дурьдахад АНУ, Монгол улстай дипломат харилцаа тогтооход олон талын хүчин зүйл нөлөөлсөн нь